

Хүүхдийн зурах дүрслэх ур чадвар, орон зайн төсөөллийг хөгжүүлэх сургалтын технологи, шинэчлэлийн үндэс

Н.Лхагва, С.Батчулуун, Г.Ариунзаяа
Монгени сургууль

Хураангуй

Монгол хүний баруун тархины хөгжлөөр илүү байх байгалийн өгөгдөхүүнийг нь идэвхжүүлэн зурах дүрслэх авьяас, ур чадварыг нь хөгжүүлэх, дүрслэх урлагийн боловсролыг олгохдоо сурагчдынхаа нас сэтгэхүйн онцлогт нь тохируулан энгийн ойлгомжтой байдлаар хөтлөн явуулах, сурагчдын уран сэтгэмжийг хөгжүүлэх, тэдэнд бие даан ажиллах чадвар эзэмшүүлэхэд илтгэлийн гол санаа чиглэгдсэн болно. Монгол хүний баруун тархины хөгжлөөр илүү байх байгалийн өгөгдөхүүнийг идэвхжүүлэн, бүхлээс хэсэгт шинжихдээ давамгайлж угшлыг хөхүүлэн дэмжих, баруун тархины хөгжлийг түлхүү дэмждэг оюун сэтгэлгээний хичээлүүдийг зохион байгуулах, хүүхэд амжилттай сурч хөгжих, өөрийнхөө авьяас чадварыг хөгжүүлж чадах тийм боломж бололцоогоор хангах, шинэ агуулга арга технологийг хөгжүүлэхэд тус монгени сургууль эрхэм зорилго оршиж байна. Байгалиас заяагдсан төрөлх гарвалыг шинжид нь түшиглэн сурагчдын зурах, дүрслэх авьяас, ур чадварыг хөгжүүлэх, сурагчдынхаа нас сэтгэхүйн онцлогт нь тохируулан дүрслэх урлагийн хичээлийг энгийн ойлгомжтой байдлаар хөтлөн явуулах, сурагчдынхаа уран сэтгэмжийг хөгжүүлэхэд анхаарч бие даан ажиллах чадвар эзэмшүүлэхэд голлон анхаарч ажиллаж байна.

Түлхүүр үг

Баруун тархи, авьяас чадвар, идэвхжүүлэх, уран сэтгэмж, ур чадвар, сэтгэхүйн онцлог, орон зайн төсөөлөл

Удиртгал

XXI зууны хүүхдүүд өөрсдийн сэтгэц, физиологи ба бодгалийн дотоод өдөөлтөөр юу хүсэж, юунд тэмүүлж буй тэрхүү сэдлээр нь хөгжүүлэх, хүсэл, мөрөөдөл, мэдлэг чадвар, зан үйлийн хэвшилд нь тулгуурлах явдал нэн чухал болж байна.

Боловсрол бол хувь хүнд байгалиас заяасан хүчийг нь зөв ухаалаг хөгжүүлэх арга зам гэсэн үзэл баримтлал өнөөдөр боловсролын тогтолцоонд зохих байр сууриа нэгэнт эзэлж эхлээд байна.

Бага насны хүүхэд бүр зураг зурж уран сэтгэмжийн барагдашгүй ундарга, хязгааргүй их мөрөөдөл, гүн утга санаа, сонирхолтой нээлт хийж, түүнийгээ аав ээж, ах дүү нартаа гайхуулан үзүүлэх дуртай байдаг билээ. Тэр дундаа Монгол хүүхдийн зураг зурах авьяас нэлээд өвөрмөц онцлогтой нь судалгаанаас ажиглагддаг. Зурах үйл ажиллагаа нь хүүхэд өөрийн ертөнцөө илэрхийлэх хэллэгийн энгийн үйл ажиллагаа юм.

Судлагдсан байдал

Эрдэмтдийн судалгаанаас үзэхэд хүүхэд бага насандаа бие хүн болон төлөвших, танин мэдэхүйн 70% орчим нь бий болдог бол тав хүртэлх насандаа зөв хүмүүжлийн 90% -ийг олж

авдаг болох нь судалгаагаар батлагдсан байна.

Хүүхэд юу зурдаг вэ? Ямар аргаар яаж зурдаг вэ? гэсэн асуудал эрдэмтэд, судлаачид, багш нарын анхаарлыг татсаар байна. Тухайлбал:

Оросын эрдэмтэн Н.П.Сакулина “Зурж дүрслэх үйл ажиллагааны үе шат үүсэн бий болсноор хүүхэд зурах арга барилыг эзэмшин өгөгдлийг ашиглан мэдрэх чадварт суралцаж байгаад гол учир оршино” хэмээн тэмдэглэсэн бол, Польшийн эрдэмтэн Вието Лованфильд хүүхдийн дүрслэн зурах хөгжлийн явцыг судлан үзээд таван үе шатанд ангилжээ.

Үүнд:

1. Сараачих үе 2-3 нас
2. Зурахын өмнөх үе 4-5 нас
3. Дүрслэн тоймлож зурах үе 5-7 нас
4. Бодит байдал руу дөхүүлж зурах үе 8-12 нас
5. Бодитоор зурах үе 12-с дээш нас гэж үзсэн байна.

Италийн эрдэмтэн К.Риччи: “Хүүхдийн шувууны мөр шиг сараачилт гол төлөв хоёр наснаас эхэлдэг. Ингэхдээ бодит зүйлийг дүрслэж чаддаггүй” хэмээн тэмдэглэсэн байна.

Судлаач Ж.Батдэлгэр /1988/ Монгол хүүхдийн сэтгэл зүйн онцлогийг судлахдаа зурж дүрслэх үйл ажиллагаа, сэтгэхүйн хөгжилд нь

нөлөөлөх тухай авч үзсэн байх бөгөөд бага насны хүүхдийн төсөөллийн гол илрэл нь зурж дүрслэх үйлийн харилцаа холбооны хооронд нарийн зүй тогтоол байдгийг ажигласан байна.

Жишээ нь: хүүхэд тархиндаа бодсон зүйлээ цаасан дээр дүрслэхдээ өөрөөр илэрхийлэх нь бий гэсэн бол Эрдэмтэн Д.Дашхүү Монгол хүүхдийн зурж дүрслэх үйл ажиллагааны онцлогийг судалсан бүтээлдээ 3-6 насны Монгол хүүхдийн зурж дүрслэх үйл ажиллагааны хөгжих онцлог, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлоод хүүхдийн гарваль шинж, дүрслэх сэтгэлгээний онцлог, түүнд нөлөөлөх хүчин зүйлтэй нь уялдуулан хөгжүүлбэл дотоод оюун сэтгэлгээгээ бүтээлчээр чөлөөтэй илэрхийлэх улмаар гоо сайхны мэдрэмж хөгжих, төлөвших суурь тавигдана гэж үзсэн байна (Дашхүү, 2001.х.47).

Хүүхэд зураг зурж эхлэх үедээ цаасан дээр муруй, тахир, урт, богино зурааснууд, толбо болон элдэв дүрс сараачдаг бол цаашдаа зориудын хөдөлгөөн болж шилждэг. Бүдүүвч дүрслэлийн үед хүүхдийн зурж дүрслэх үйл ажиллагааны хөгжилд шинэ үе шат эхэлдэг. Энэ үед хүүхдийн орчиндоо хандах хандлага, дүрслэлийн арга хэрэгслүүдийг эзэмших, ашиглах, зурах чадварт шинэ шинэ өөрчлөлт гардаг болохыг эрдэмтэн С.Батчулуун ажигласан байна (2011, х.19). Нас насанд хүүхдийн сэтгэцийн хөгжил харилцан адилгүй явагдах бөгөөд сэтгэцийн хөгжлийн тодорхой үе шат, онцлогоор хүүхдийн насны үечлэл тодорхойлогддог. Тухайлбал,

Хүүхдийн насны үечлэлийг:

1. Нярай насны хүүхэд (0-1 нас)

2. Балчир насны хүүхэд (1-3 нас)
3. Цэцэрлэгийн насны хүүхэд (3-6 нас)
4. Бага насны хүүхэд (6-12 нас)
5. Өсвөр насны хүүхэд (12-16) (Шилжилтийн нас)
6. Ахлах ангийн хүүхэд (16-18 нас) гэж ангилан үздэг болно.

Монгол хүний баруун тархины хөгжлөөр илүү байх байгалийн өгөгдөхүүнийг идэвхжүүлэх, бүхлээс хэсэгт шилжихдээ давамгайлж угшлыг хөхиүлэн дэмжих, баруун тархины хөгжлийг түлхүү дэмждэг оюун сэтгэлгээний хичээлүүдийг зохион байгуулах, хүүхэд амжилттай сурч хөгжих, өөрийнхөө авьяас чадварыг хөгжүүлж чадах тийм боломж бололцоогоор хангах, шинэ агуулга арга технологи зайлшгүй шаардлагатай байна гэсэн санааг 1992 онд судлаач, Н.Лхагваагийн дэвшүүлэн тавьсан нь одоо амжилттай хэрэгжиж байна (2010,96). Бидний боловсруулсан сурагчдын зурах дүрслэх авьяас, ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр нь Дүрслэх урлагийн хичээлийг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан энгийн ойлгомжтой байдлаар заах, сурагчдын уран сэтгэмжийг хөгжүүлэх, тэдэнд бие даан ажиллах чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэж байна (Лхагваа, 2012).

Судалгааны хэсэг

Энэхүү сургалтын хөтөлбөрийн туршилт нь Монгени цогцолбор сургууль дээр 2010 оноос эхэлж 1-9 ангийн сурагчдын хүрээнд одоог хүртэл хэрэгжиж, үр дүн нь баталгаажиг байна.

Хүснэгт 1

Хувьсах агуулга буюу зэрэгцсэн сургалтаар зурж, дүрслэх ур чадвар, орон зайн төсөөллийг хөгжүүлэх хөтөлбөрийн үндсэн загвар

Сургалтын технологи	Үе шат	Орц буюу суралцагчийн мэдлэг чадварын нөөц	Гарц буюу хүрэх Үр дүн
ХӨГЖӨӨХ	1-р шат Анхан шатны боловсрол /1-5-р анги/	Сургуулийн өмнөх шатны боловсролоор олж авсан болон хүүхдийн өөрийнх нь зурах- дүрслэх аргаар бодол санаа, хүсэл эрмэлзлээ илэрхийлэх, төрөлх авьяасыг нь хөгжөөн бадрах зорилгоор юмс үзэгдлийг танин мэдэх, зурах, дүрслэх арга, материал, багаж хэрэгсэлтэй харьцах, зөв арга барил эзэмшүүлэх, зураас, цэг, толбо, өнгө, дүрс, биет, орон зай, харьцаа, орчин, аж байдал, Монгол ахуй амьдрал, хэрэглээний эд зүйлс, байгаль, өөрийн дуртай мал амьтан дүрслэх, чөлөөт сэтгэлгээг нь хөгжүүлэх, зохиомжлон зурах- дүрслэх анхан шатны төрөл бүрийн арга барил эзэмшүүлэхэд чиглэгдэнэ.	Зурах дүрслэлийн хэл болох үндсэн элементүүдтэй танилцах, материал болон багаж хэрэгслийг оновчтой ашиглах, зураг- дүрслэлийн арга ажиллагааг дасгал, дадлага ажлуудаар чадварыг нь нэмэгдүүлэн сонирхолтой сэдэв сонгох, зураг- дүрслэлийн элемент, тоог ахиулах, төрөл бүрийн арга барилыг турших боломж олгох, чөлөөт сэтгэлгээг хөгжөөх, хамтран ажиллах, бүтээлч хандлагыг дээшлүүлнэ.

<p>ХӨХИҮҮЛЭН ДЭМЖИХ</p>	<p>2-р шаг Суурь боловсрол /6-9-р анги/</p>	<p>Зурах- дүрслэх анхан шатны боловсролоор олж авсан авьяас чадварыг юмс үзэгдлийн хэлбэр дүрс, хэмжээ харьцаа, хөдөлгөөн, хэмнэл, тэгш ба тэгш бус хэм, өнгө, дүрсийн бэлгэдэл, зохиомжийн зүй тогтол, гэрэл сүүдэр, алслалтын тухай суурь мэдлэг олж авах, өнгө будгаар ажиллах, төрөл бүрийн арга техникээс суралцах, байгаль, уул,ус, үүл, улирал, цаг агаар, амьд ертөнц, хүн дүрслэл, Монголын болон дэлхийн улс гүрнүүдийн эртний, дундад зууны, сонгодог үеийн, ХХ-р зууны, орчин үеийн дүрслэх урлагийн түүхээс судлах, тэдгээрийн онцлог, нэрт уран бүтээлчдийн зурах дүрслэх арга барилтай танилцах, суралцах, дүрслэх урлаг- дизайны төрөл, жанруудыг мэдэх, орон зай- чимэглэлийн урлаг, Монгол зураг, ардын гар урлал, уран сайхны бичлэг /калиграф/, орон зайн урлал- уран баримал, шуумал, шигтгэмэл /мозайка/, керамик, сийлбэрлэх урлалын анхан шатны арга барилуудаас суралцаж, янз бүрийн материал ашиглах, технологиос суралцах, чөлөөтэй сэтгэн бодож, зохиомжлох, хуулбарлах, шинэ санаа гаргах,эскиз хийх,бүтээлчээр хандлагыг аль болох дэмжих сургалтууд явагдана.</p>	<p>Зурах-дүрслэх авьяас чадварыг улам дээшлүүлж юмс үзэгдлийн хэлбэр дүрс, хэм төрөл бүрийн арга техникээс суралцах, хэмжээ харьцаа, хөдөлгөөн хэмнэл, тэгш ба тэгш бус хэм, өнгө, дүрсийн бэлгэдэл, зохиомжийн зүй тогтол, гэрэл сүүдэр, алслалтын тухай суурь мэдлэг олж авч, өнгө будгаар ажиллах, байгаль, уул, ус, үүл, улирал, цаг агаар, амьд ертөнц, хүн дүрслэл, Монголын болон дэлхийн улс орнуудын эртний, дундад зууны, сонгодог үеийн, ХХ-р зууны, орчин үеийн дүрслэх урлагийн түүхээс судлах, тэдгээрийн онцлог, нэрт уран бүтээлчдийн зурах дүрслэх арга барилтай танилцах, суралцах, дүрслэх урлаг- дизайны төрөл, жанруудыг мэдэх, орон зай- чимэглэлийн урлаг, Монгол зураг, ардын гар урлал, уран сайхны бичлэг /калиграф/, орон зайн урлал- уран баримал, шуумал, шигтгэмэл /мозайка/, керамик, сийлбэрлэх урлалын анхан шатны арга барилуудаас суралцаж, янз бүрийн материал ашиглах, технологиос суралцах, чөлөөтэй сэтгэн бодож, зохиомжлох, хуулбарлах, шинэ санаа гаргах, эскиз хийх, бүтээлчээр хандах чадвартай болно.</p>
<p>ХӨГЖҮҮЛЭХ</p>	<p>3-р шаг Ахлах сургуулийн боловсрол /10- 12-р анги/</p>	<p>Суурь боловсролын шатнаас олж авсан мэдлэг, авьяас чадвараа ашиглан цаашид их, дээд сургуульд элсэн орох, мэргэжлийн баримжаа олж авах зорилгоор:</p> <p>Заавал судлах мэргэжлийн суурь хичээл</p> <ul style="list-style-type: none"> - Хар зураг, дүрс судлал - Өнгөт зураг, өнгө судлал - Зурах технологи судлал - Зохиомж, сэтгэлийн дүрслэхүй <p>МБ олгох сонгон судлах лицей сургалт</p> <ul style="list-style-type: none"> - Монгол зураг судлал - Ардын уламжлалт гар урлал /зээгт наамал, эсгий урлал, уран дарханы урлал, г.м / - Уран баримал - Шигтгэмэл /мозайк/ урлаг - Сийлбэрлэх урлаг <p>зэрэг чиглэлүүдээр сурагчид хичээлийн бус цагаар сонгон суралцах хэлбэрийн сургалтууд явагдана.</p>	<ul style="list-style-type: none"> - Хар зураг, өнгөт зураг судлалын хичээлүүдээр харааны мэдрэмж, ой тогтоолт, ажиглах чадвар, ур чадвар, хийсвэрлэн сэтгэх зэрэг чанаруудыг дэс дараатай хөгжүүлнэ. - Зурах технологи судлалаар нэрт уран бүтээлчдийн бүтээлийг хуулбарлах замаар зурах арга технологийг судалж, уран бүтээл хийх дэс дараа, технологи ажиллагаанд суралцана. - Зохиомж, сэтгэлийн дүрслэхүйн ухаанаар чөлөөт сэтгэлгээ, уран сайхны хийсвэрлэх сэтгэлгээг идэвхжүүлэх, ур чадварыг дадлагажуулах, хэвшүүлэх, зохиомжийн олон хувилбарыг сонгох, өнгө тооны уялдаа холбоо, ургуулан бодох сэтгэлгээг нь хөгжүүлэхэд чиглэгдэнэ. - МБ олгох сонгон судлах лицей сургалтад хамрагдсанаар <p>Үндэсний уран зураг, ардын гар урлал, дэлхийн сонгодог болон орчин үеийн орон зайн урлалын мэргэжлийн чиг хандлагуудаас бүтээлчээр суралцах чадвар эзэмшинэ.</p>

Судалгаанаас үзэхэд бага насны хүүхэд байгуулалт төдийлөн хийдэггүй зөвхөн өөрсдийн бодол санаанд хөтлөгдөн чөлөөтэй сэдэв дүрслэлийг сонгох нь илүүтэй байна. Хүүхдийн энэхүү зан чанар, сэтгэхүйн онцлог, төрлөх гарваль шинжид тулгуурлан сургалтыг явуулах нь сургалтын гол зарчим болон хэрэгжиж байна.

- Бага ангийн хүүхдийн сэтгэл зүйн онцлог нь
- Юмс үзэгдлийг сэтгэлийн хөдөлгөөний их өрнөлттэйгөөр тусган авах
 - Хараа, сонсголын сэрэл өндөр байх
 - Санамсаргүй, зориудын биш тогтоолт дүрслэл ба сэтгэл хөдлөл ихтэй байх
 - Хүүхдийн зохион бодохуй, дүрслэл нь уран зөгнөлийн шинжтэй байх

- Бодит юмс үзэгдлийг гярхай ажиглан, хөдөлгөөний хэтрүүлэлтэй дүрслэлийг эрмэлздэг зэрэг болно.

Дээр дурдсан онцлогийг хичээл удирдан явуулж буй багш, сурган хүмүүжүүлэгч нар анхаарч ажиллах, хүүхдийн авьяас чадвар хөгжих нь тэдний бүтээлч үйл ажиллагаагаар хэрэгждэг билээ. Иймд багш нар дараах зарчмыг удирдлага болгож ажиллах нь зүйтэй юм. Үүнд:

1. Сэдэв сонгох төлөвлөх зарчим
- Хүүхдүүд өөрийн сонирхсон сэдэв, дүрслэлийн аргадаа тулгуурлан зурах сэдвээ чөлөөтэй сонгон авна. Багш сонгосон сэдвийн хүрээнд хамтран ярилцаж, бүтээлээ төлөвлөх, хэрхэн зохиомжлох

тухай зөвлөн ажилласнаар хүүхдийн бүтээлч сэтгэхүй хөгжиж, сэтгэлгээний уян хатан чанарыг эзэмших, аливаа үйлийн технологи эзэмших, эрчимтэй хөдөлмөрийн арга барилд суралцаж бүтээхэд суралцана.

2. Дадал эзэмшүүлэх зарчим

Хүүхэд насны хүслэн, сэтгэл зүйн нэг онцлог нь олон зүйлийг мэддэг, чаддаг болох явдал байдаг. Бүтээл хийн суралцахад хөдөлмөр зохион байгуулалт, хөдөлмөрлөх дадалд сайн сурснаар бүтээл хийх эрч хүч, урам зориг нэмэгддэг байна.

3. Бие даан ажиллахад сургах зарчим


Хүүхдийг бие даан ажиллахад төгс сайн сургах нь бүтээлч хүн болохын нэг үндэс юм. Үүнд: Мэдлэг олгох, зураг дүрслэлийн аргад сургах, зохиомж боловсруулах, дасгал ажлыг давтамж олонтой хийлгэх, дадлага суулгах, гүйцэтгэх чадвар, тэвчээртэй, хичээнгүй чанар эзэмших, өөртөө шүүмжлэлтэй хандах зэргээр бие даан бүтээл хийдэг болгоход чиглэгдэнэ.

4. Бүтээлийн технологийг хатуу баримтлах зарчим

Бүтээл хийхэд зохиомжийн хэсэг бүрд технологийн тодорхой шийдэлтэй тулгардаг. Энэ нь алхам бүрдээ хүүхдээс арга, эв дүй, ур ухаан, багаж эзэмших чадвар шаардана. Бүтээл хийх явцад багш байнга хяналт тавьж, хүүхдийг анхнаас нь зөв чиглүүлж, зорилгодоо хүрэх арга ухаанд сургах талд нь чиглүүлж өгөх шаардлагатай байна.

5. Түрүүлж сургах зарчим

Бүтээл хийх ажил нь хүүхдээс зурах дүрслэх чадвар, ажлын дадал, зохих цаг хугацаа зарцуулсан хөдөлмөр, оюун бодол, эв дүй шаарддагаараа дүрслэлийн дээд хэлбэр гэж үзэж болно. Хүүхдийн уран бүтээл бол хүүхдийн хөгжлийн өндөр түвшин, түрүүлсэн сургалтын үр дүн гэж үзэж болно.



Охид хөвгүүдийн зургийн зохиомжийн дүрслэл, өнгийн сонголт зэрэг нь ихэнх тохиолдолд өөр өөр байдаг. Тухайлбал: Охид ихэнхдээ дугуй дүрс орсон цэцэг, байгаль, зэрэг дүрслэл зурдаг бол хөвгүүд өнцөг, шулуун зураас зэргийг ашиглан машин, хот, зам зэргийг зурдаг байна.

Хөвгүүдийг бодвол охид илүү солонгорсон тод, дулаан өнгийг илүү зургандаа ашигладаг бол, хөвгүүд ихэвчлэн хүнд өнгө тэр дундаа цэнхэр өнгийг давамгайлан хэрэглэдэг. Мөн хүүхдүүд өөрт дотно, ойр хүмүүсийг тод өнгөөр будах нь элбэг байдаг. Тухайлбал, хэрвээ хүүхэд хэн нэгнийх нь цамцыг хөх өнгөөр зурсан, тагласан бол энэ хүнтэй амар тайван харилцаатайг илэрхийлдэг.

Хэрэв ногоон өнгөөр будсан бол энэ хүнийг хүндэлдэг, чухал нэгэн болохыг илэрхийлдэг бол аливаад сэтгэл хөдлөлөөр ханддаг, түргэн зантай хүнийг шар өнгөөр, түрэмгий зантай бол улаан өнгөөр, харин хар өнгөөр өөрт таалагддаггүй таагүй зан байдлыг илэрхийлдэг байна.

Зураг зурах, баримлаар тоглох, шүрээр юм хийж сурах зэрэг нь бүгд хүүхдийн хүрч мэдрэх, анхаарлаа төвлөрүүлэх чадварыг хөгжүүлдэг. Энэ нь хамгийн чухал чадваруудын нэг юм. Мөн хүүхэд бичиж сурахаасаа өмнө дүрслэлийн анхны элементүүд болох зураас, дүрс, өнгийн ялгарлыг зөв мэдэрч авснаар гарын хөдөлгөөн болон сэтгэхүйн мэдрэмжээр өөрт мэдээллийг хуримтлуулж, өөрийгөө аажмаар хөгжүүлж, ой тогтоолтын чадварыг бий болгодог байна.

Монголын ахуй амьдрал, уламжлалт тоглоом наадгай бүхэн нь хүүхдийн хүмүүжлийн болоод сэтгэхүйг хөгжүүлэх, хэл яриаг зүгшрүүлэх, хөдөлгөөний эв дүйтэй, хийсэн ажилдаа урамших сэтгэлзүйг бий болгохоос гадна мөн хүүхдийг олон талын урлахуйн ухаанд сургадаг. Хүүхдийн дүрслэн зурах арга ухаан үүнтэй мөн хамааралтай байна.

Хүүхэд зурах тусам дүрслэн урлах хэв маяг, арга ухаанд улам дадлагаждаг. Хүүхдэд янз бүрийн чимэглэл ажиглуулан өөрт ойр зүйлстэй нь зүйрлэн ярилцаж, хялбар зохиомжтой, тэгш хэмтэй зураг зуруулах нь хүүхдийн зурах сонирхлыг улам өдөөж, урмыг сэргээдэг байна.

Зураг зурах үед хүүхэд зохиомжийн дүрслэл, өнгийн сонголт, зургийг уншиж сурах зэрэгт суралцдаг. Энэ нь цаашид өсөж том болоод шинийг санаачлах чадвар, зохион бүтээх, бүтээлч сэтгэлгээнд нь тус нэмэр болдог байна. Зураг зурснаар хүүхдийн сурах, суралцах чадварыг нь хөгжүүлж өгдөг байна. Зураг зурах нь бусад

чадвартай харилцан хамааралтай байдаг байна. Судалгаагаар долоо хоногийн 3 өдөр өдөрт 3 цагаар зургаар хичээллэдэг хүүхдүүдийг зургаар огт хичээллэдэггүй хүүхдүүдтэй харьцуулж үзвэл, Зургаар хичээллэдэг хүүхдүүд нь хичээллэдэггүй хүүхдүүдээс математик болон бусад хичээлүүд дээр илүү сайн байгаа нь ажиглагдаж байна. Энэ нь хүүхэд зурах явцдаа анхаарлаа төвлөрүүлэх, сэтгэн бодох, төсөөлөн зурдагтай нь холбон тайлбарлаж болох юм. Хүүхэд уншсан зүйлийнхээ агуулгыг зургаар илэрхийлэхдээ сонирхолтойгоор зурдаг байна. Хүүхдэд насанд нь тохирсон үйл явдалтай, юмсын дүрслэлийг тодотгон бичсэн, үлгэр болон жижиг хэмжээний зохиол уншиж өгөх нь хүүхэд тархиндаа төсөөлөн бодох, өөрийн оюун сэтгэлдээ шинэ ертөнцийг дүрслэн амилуулдаг. Улмаар зурсан зүйлийнх нь талаар хүүхдээр тайлбарлан яриулж байх нь хамгийн зөв бөгөөд үүгээр дамжуулан хүүхэд өөртөө итгэлтэй болж, өөрийн үзэл бодлоо чөлөөтэйгөөр илэрхийлж сурдаг байна.

Эцэст нь тэмдэглэхэд Монгол хүүхдийн баруун тархины хөгжлөөр илүү байх байгалийн өгөгдөхүүнийг нь идэвхжүүлэн, өөрт байгалиас заяагдсан төрөлх гарваль шинжид нь түшиглэн сурагчдын зурах, дүрслэх авьяас, ур чадварыг хөгжүүлэх, сурагчдынхаа нас сэтгэхүйн онцлог нь тохируулан Дүрслэх урлагийн хичээлийг

энгийн, ойлгомжтой байдлаар хөтлөн явуулах, сурагчдынхаа уран сэтгэмжийг хөгжүүлэхэд голлон анхаарч, бие даан ажиллах чадвар эзэмшүүлэхэд чиглэгдэж байна.

Монгол хүний баруун тархины хөгжлөөр илүү байх байгалийн өгөгдөхүүнийг идэвхжүүлэх, бүхлээс хэсэгт шилжүүлэхдээ давамгайлж уг шинжийг хөхүүлэн дэмжих, баруун тархины хөгжлийг түлхүү дэмждэг оюун сэтгэлгээний хичээлүүдийг зохион байгуулах, суралцахуйн шинэ орчин, шинэ хэв шинж, шинэ агуулга арга технологийг хэвшүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна.

Ашигласан материал

- Дашхүү, Д. (2001). Сургуулийн өмнөх насны Монгол хүүхдийн зураг дүрслэлийн онцлог. Улаанбаатар
- Лхагва, Н. (2010). Боловсролын үйл хэрэгт иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь. Багш сонин. № 96. Улаанбаатар.
- Батчулуун, С. (2011). Нүүдэлчдийн урлаг, соёлын жимээр мөшгөхүй. Улаанбаатар: Сансудуй хэвлэл
- Лхагва, Н., Батчулуун, С. (2012). Зурж, дүрслэх ур чадвар, орон зайн төсөөллийг хөгжүүлэх хөтөлбөр. Улаанбаатар

The basis for reform to develop technology of training at children's drawing skills and spatial imagery

*N.Lhagva, S.Batchuluun, G.Ariunzaya
Secondary school of Mongeni*

Abstract

Mongolian people's right brain is developing. Therefore, their understanding of drawings skills is improving. However, we try to know how to give art education to our students. In remembering though, that even the greatest talent and drawing skills will only take you so far. In the end, it's the creativity and ideas that matter. Artists have to think and make choices in their work-this is what distinguishes an artist from someone who is simply technical adept. We purpose to ability of student drawing skills. Students develop knowledge and understanding about intention, appreciation, and reflection, alongside experimental and more traditional drawing skills. Our article's main points are to develop creative mind and self-teaching to each other.

Secondary School of Mongeni's purposes are students' creativity, ingenuity, and thinking outside the box begins for child development. Imaginative and creative play is how children learn about the lesson. During imaginative play, children manipulate materials, express themselves verbally and non-verbally, plan (intentionally or unintentionally), act, interact, react, and try different roles. Great opportunities for learning are possible when children participate in creative play with dolls, vehicles, blocks, rocks, cardboard, or boxes. They benefit of nature for child development are endless. Because nature is ever changing, it provides countless opportunities for discovery, creativity, and problem solving. The natural world inspires children to think, question, make suppositions, and develop creative minds. We are try to work improve our student's creative mind all of the time.

key words

bright brain, talents, activate, the imagination, drawing skills, the psychological features and the spatial imagery.